

“Хоёр улиас”

1. Дараах хэлцээс аль нь “дураараа байх” гэсэн утгыг илэрхийлсэн бэ?

- A. Насыг элээх
- B. Эрийн цээнд хүрэх
- C. Голомтыг асаах
- D. Жаргалдаа ташуурах
- E. Ухаандаа багтааж чадах

2. Эхэд дэвшүүлсэн асуудал буюу сэдвийг олоорой

- A. Залуу насны тухай
- B. Дарьчин өвгөний тухай
- C. Харуусал гэмшлийн тухай
- D. Эцэг эхийн тухай
- E. Хоёр улиасны тухай

3. Эхийн гол санааг хадгалсан өгүүлбэр аль нь вэ?

- A. Эцэг маань намайг эрхлүүлдэг байжээ. Би чинь багадаа бархирч айлгадаг байлаа, муу эцгийгээ
- B. Үр болсон биднийгээ л гэж насыг элээсэн хүн
- C. Эцэг маань намайг арван найман нас хүрсэн залуу эрийн нялх хүүхэд адил санадаг байж дээ
- D. Хүн гэдэг чинь эцэг эх болсон хойноо л сая эцэг эхийн ачийг ухаандаа багтааж чаддаг бөгөөд ачийг нь хариулья гэтэл хожимдсон байдаг нь голдуу л даа
- E. Нэг өдөр би тэднийд очоод л дүрсгүй зан хөдлөөд болдоггүй

4. Хоёр улиас залуу насны алдаа эндэгдлийг санагдуулан өвгөний сэтгэлд харамсал гэмшил үлдээснийг илэрхийлэх өгүүлбэр аль нь вэ?

- A. Алхуут нөгөө улиасны зүг хулмалзан харж сүүрс алдана
- B. Өвгөн улаач модны хажуугаар гардаг зам дээр ирмэгц мориныхоо амыг татан явгаллаа.
- C. Өвгөн хөмсөг зангидан морио хөтлөн бөгцгөнөн алхав
- D. Мянга мянган навчис чичрэн далбалзаж ,эртний домог шивнэх шиг болов
- E. Өвгөн мориндоо мордон үг дуугүй цааш алхуулав

5. Өвгөн яагаад хоёр улиасны тухай залуу багшид ярих болов

- A. Залуу сониучирхаад байсан учир
- B. Нас нь өвгөрсөн учраас
- C. Эцгээ дурсан санасан учраас
- D. Өөрийн алдааг дахин ойлгуулах гэж бодсон учраас
- E. Шавь нартаа энэ болчимгүй зүйлийг ухааруулж ойлгуулаасай гэж бодсон учраас

Түлхүүр

1D

2 C

3D

4A

5E